ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

Орхон сумын ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ДАА-2026/3/НА-СТА-ТТЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br><br>Дархан-Уул аймаг<br>2025 он | Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр<br>Утас: 7037-3089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn<br><br>Аудитын менежер У.Батсүрэн<br>Утас: 7037-3089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор С.Батцэцэг<br>Утас: 7037-3089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт


ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn


2026.03.25 № 190

танай ______ -ны № ______ -т

ОРХОН СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.ТҮМЭНЦОГТ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Орхон сумын ТЕЗ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улсын Сангийн яам болон Дархан-Уул аймгийн ЗДТГ хооронд байгуулсан Азийн хөгжлийн банкны эх үүсвэрээр хэрэгжсэн "Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН-3244/3245 төсөл"-ийн дамжуулан зээлийн өрөнд тус сумын орон нутгийн төсвөөс 342.6 сая төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд сумын төсвийн нийт зарлагын 49.2 хувь буюу 1,860.0 сая төгрөгийг аймгийн төсвөөс сумын төсөвт олгох санхүүгийн дэмжлэг авч, төсвийн

4526050322

төвлөрүүлэн захирагчийн харьяаны байгууллагуудын үйл ажиллагааны санхүүжилтийг олгосон байна.

**Бусад асуудал**

Төсвийн ерөнхийлөн захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Сумын Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны 19 зорилт, 83 арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг Орхон сумын ИТХ-аар 99.2 хувиар үнэлүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ш.МӨНХБАЯР

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Дансны нэр, төрөл | Тодруулга | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | | **796,488,839.19** | **1,031,579,292.21** |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 3а, 3б | 323,602,036.23 | 131,774,036.07 |
| 33 | АВЛАГА | 5а, 5б, 6а, 6б | 224,428,326.54 | 308,530,546.90 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 8а, 8б, 8в | 237,488,876.42 | 572,040,109.24 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | 9а | 10,969,600.00 | 19,234,600.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | 10 | **4,685,941,691.37** | **4,626,960,287.53** |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | | 4,685,941,691.37 | 4,626,960,287.53 |
| 39200 | Биет хөрөнгө | 12а, 12б, 12в | 4,464,925,001.60 | 4,407,907,707.61 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 13 | 221,016,689.77 | 219,052,579.92 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | | **5,482,430,530.56** | **5,658,539,579.74** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | 14 | **36,557,936.00** | **94,212,505.38** |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | | 36,557,936.00 | 94,212,505.38 |
| 41300 | Өглөг | | 36,557,936.00 | 94,212,505.38 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | | **5,445,872,594.56** | **5,564,327,074.36** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | | 5,445,872,594.56 | 5,564,327,074.36 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | | 769,976,677.02 | 769,976,677.02 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | | 769,976,677.02 | 769,976,677.02 |
| 51101 | Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | | 111,595,600.00 | 111,595,600.00 |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/ | | 2,472,960,883.00 | 2,722,948,383.00 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | | 464,106,728.62 | 332,573,708.42 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 1,627,232,705.92 | 1,627,232,705.92 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | | **5,482,430,530.56** | **5,658,539,579.74** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| № | Дансны нэр, төрөл | Тодруулга | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | | **4,590,066,968.87** | **5,099,265,108.86** |
| 2 | ТАТВАРЫН ОРЛОГО | | 887,122,317.39 | 964,872,080.03 |
| 3 | Орлогын албан татвар | | 569,280,802.79 | 669,996,980.25 |
| 4 | Хөрөнгийн албан татвар | | 185,841,890.11 | 156,217,937.41 |
| 5 | Бусад татвар, төлбөр, хураамж | | 131,999,624.49 | 138,657,162.37 |
| 6 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1а, 1б | 1,422,084,601.48 | 4,134,393,028.83 |
| 7 | Тусламжийн орлого | | 0.0 | 1,890,462,043.00 |
| 8 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | | 2,280,860,050.00 | |
| **9** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2а, 2б** | 3,452,448,177.29 | 4,309,413,205.22 |
| 10 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 3,452,448,177.29 | 4,309,413,205.22 |
| 11 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 2,951,778,887.29 | 3,846,013,945.22 |
| 12 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 1,235,780,066.60 | 1,089,907,312.11 |
| 13 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 154,527,183.95 | 133,317,915.07 |
| 14 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 708,534,535.47 | 615,597,722.31 |
| 15 | Хангамж, бараа материалын зардал | | 115,258,070.48 | 62,316,066.06 |
| 16 | Нормативт зардал | | 7,133,640.00 | - |
| 17 | Эд хогшил, урсгал засварын зардал | | 127,721,167.10 | 136,070,400.00 |
| 18 | Томилолт, зочны зардал | | 12,036,000.00 | 6,969,000.00 |
| 19 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 140,186,266.44 | 1,486,480,509.18 |
| 20 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 450,601,957.25 | 315,355,020.49 |
| 21 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 500,669,290.00 | 463,399,260.00 |
| **22** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | | **1,137,618,791.58** | **789,851,903.64** |
| **23** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | | **1,121,256,401.72** | **908,122,539.84** |
| **24** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)** | | **(1,121,256,401.72)** | **(908,122,539.84)** |
| **25** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)** | | **16,362,389.86** | **(118,270.636.20)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| № | Дансны нэр, төрөл | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **3,839,334,205.45** | **4,307,127,881.05** |
| **2** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **887,122,317.39** | **964,872,080.03** |
| 3 | Орлогын албан татвар | 569,280,802.79 | 669,996,980.25 |
| 4 | Хөрөнгийн албан татвар | 185,841,890.11 | 156,217,937.41 |
| 5 | Бусад татвар, төлбөр, хураамж | 131,999,624.49 | 138,657,162.37 |
| 6 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 58,164,302.89 | 73,911,197.77 |
| 7 | Газрын төлбөр | 61,960,007.00 | 55,631,822.00 |
| 8 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 11,875,314.60 | 9,114,142.60 |
| **9** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **693,805,538.06** | **3,342,255,801.02** |
| 10 | Нийтлэг татварын бус орлого | 693,805,538.06 | 818,177,458.02 |
| 11 | Тусламжийн орлого | 0.0 | 1,890,462,043.00 |
| 12 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 0.0 | 633,616,300.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,258,406,350.00** | **0.0** |
| **14** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **3,166,786,973.61** | **3,700,198,022.21** |
| **15** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,166,786,973.61** | **3,700,198,022.21** |
| 16 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,668,512,233.61 | 3,226,365,212.21 |
| 17 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,242,196,576.19 | 1,583,579,511.78 |
| 18 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 158,533,061.51 | 133,317,915.07 |
| 19 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 729,012,862.47 | 857,034,358.14 |
| 20 | Хангамж, бараа материалын зардал | 120,383,687.00 | 157,765,082.00 |
| 21 | Нормативт зардал | 1,050,000.00 | 0 |
| 22 | Эд хогшил, урсгал засварын зардал | 96,166,750.00 | 139,269,000.00 |
| 23 | Томилолт, зочны зардал | 11,476,000.00 | 6,969,000.00 |
| 24 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 196,541,576.44 | 232,670,185.22 |
| 25 | Бараа үйлчилгээний бусад зардал | 113,151,720.00 | 115,760,160.00 |
| 26 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 498,274,740.00 | 473,832,810.00 |
| **27** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **672,547,231.84** | **606,929,858.84** |
| **28** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН** | **1,038,091,791.00** | **676,477,859.00** |
| 29 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 1,038,091,791.00 | 676,477,859.00 |
| 30 | Дотоод эх үүсвэрээр | 1,038,091,791.00 | 676,477,859.00 |
| 31 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (1,038,091,791.00) | (676,477,859.00) |
| 32 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 58,000,000.00 | 122,280,000.00 |
| 33 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | (58,000,000.00) | (122,280,000.00) |
| 34 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | (423,544,560.16) | (191,828,000.16) |
| 35 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 747,146,596.39 | 323,602,036.23 |
| 36 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 323,602,036.23 | 131,774,036.07 |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Данс-ны код | Дансны нэр, төрөл | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,120,481,890.02** | **1,627,232,705.92** | **447,744,338.76** | **4,195,458,934.70** |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,120,481,890.02** | **1,627,232,705.92** | **447,744,338.76** | **4,195,458,934.70** |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 146,000,000.00 | 0.00 | 0.00 | 146,000,000.00 |
| 6 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 7 | Өмчид гарсан өөрчлөлт | 1,088,051,270.00 | 0.00 | 0.00 | 1,088,051,270.00 |
| 8 | Зарласан ногдол ашиг | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 16,362,389.86 | 16,362,389.86 |
| **10** | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **3,354,533,160.02** | **1,627,232,705.92** | **464,106,728.62** | **5,445,872,594.56** |
| **11** | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **3,354,533,160.02** | **1,627,232,705.92** | **464,106,728.62** | **5,445,872,594.56** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | (13,262,389.86) | (13,262,389.86) |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **3,354,533,160.02** | **1,627,232,705.92** | **450,844,344.62** | **5,432,610,210.56** |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 249,987,500.00 | 0.00 | 0.00 | 249,987,500.00 |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 17 | Өмчид гарсан өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 18 | Зарласан ногдол ашиг | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | (118,270,636.20) | (118,270,636.20) |
| **20** | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **3,604,520,660.02** | **1,627,232,705.92** | **332,573,708.42** | **5,564,327,074.36** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Дансны нэр, төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **1** | **НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **3,773,109,500.00** | **3,582,275,054.08** | **(44,904,545.92)** | **94.9** |
| 11 | Татварын орлого | 973,900,000.00 | 964,872,080.03 | (9,027,919.97) | 99.1 |
| 12 | Татварын бус орлого | 155,903,400.00 | 123,786,674.05 | (32,116,725.95) | 79.4 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 155,903,400.00 | 123,786,674.05 | (32,116,725.95) | 79.4 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/ | 140,903,400.00 | 57,683,642.30 | (83,219,757.70) | 40.9 |
| 120009 | Бусад орлого | 15,000,000.00 | 66,103,031.75 | 51,103,031.75 | 440.7 |
| 122 | Тусламжийн орлого | 2,643,306,100.00 | 2,493,616,300.00 | (3,759,900.00) | 94.3 |
| 122003 | Аймаг нийслэлээс авсан татаас | 1,863,759,900.00 | 1,860,000,000.00 | (3,759,900.00) | 99.8 |
| 123002 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого | 633,616,300.00 | 633,616,300.00 | - | 100.0 |
| | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 145,929,900.00 | - | (145,929,900.00) | - |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **3,773,109,500.00** | **3,773,598,790.16** | **489,290.16** | **100.0** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 3,001,278,900.00 | 2,703,448,481.16 | (297,830,418.84) | 90.1 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,527,577,600.00 | 2,243,313,871.16 | (284,263,728.84) | 88.8 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,116,415,900.00 | 1,089,658,092.78 | (26,757,807.22) | 97.6 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 139,551,900.00 | 133,317,915.07 | (6,233,984.93) | 95.5 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 723,280,000.00 | 613,437,722.31 | (109,842,277.69) | 84.8 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 36,107,500.00 | 24,376,750.00 | (11,730,750.00) | 67.5 |
| 2105 | Норматив зардал | 1,072,400.00 | - | (1,072,400.00) | - |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 174,420,400.00 | 171,886,000.00 | (2,534,400.00) | 98.5 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 15,666,900.00 | 6,969,000.00 | (8,697,900.00) | 44.5 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 124,926,100.00 | 99,558,231.00 | (25,367,869.00) | 79.7 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 196,136,500.00 | 104,110,160.00 | (92,026,340.00) | 53.1 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 143,328,400.00 | 129,761,710.00 | (13,566,690.00) | 90.5 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 101,295,400.00 | 93,938,110.00 | (7,357,290.00) | 92.7 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 42,033,000.00 | 35,823,600.00 | (6,209,400.00) | 85.2 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 643,010,500.00 | 607,249,209.00 | (35,761,291.00) | 94.4 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 128,820,100.00 | 122,280,000.00 | (6,540,100.00) | 94.9 |
| | Дамжуулан зээлийн төлбөр | | 340,621,100.00 | | |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **320,609,178.28** | **320,609,178.28** | **-** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **-** | **129,285,442.20** | **129,285,442.20** | **-** |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **28,462,043.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | |
| **12213** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **28,462,043.00** |
| 350011 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 5,000,000.00 |
| 350014 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 23,462,043.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **28,462,043.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **28,462,043.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **27,012,043.00** |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 10,347,262.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,014,781.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,650,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,450,000.00** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,450,000.00 |

**Гурав. Аудитын илрүүлэлт:** Аудитаар нийт 176.9 сая төгрөгийн 2 алдаа[1] илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

1. Санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоож, хүлээн зөвшөөрөхдөө ЗДТГ 42.3 сая төгрөгийн орлогын дансыг ангилал буруу бүртгэсэн нь УСНББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 10.42(ж), “Толилуулга”, “Ангилал” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул санхүүгийн үр дүнгийн тайланд “Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө” дансыг бууруулж, “Бусад орлого” дансыг нэмэгдүүлж залруулав.

2. Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайланд “Орхон тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын нийт 134.6 сая төгрөгийн зардлыг ангилал зөрүүлэн бүртгэсэн нь Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "ААН-ийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын 5 дугаар бүлгийн 1 дэх заалттай нийцэхгүй, “Ангилал”, “Толилуулга” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгаа тул бараа материал худалдан авахад төлсөн зардал, бусад мөнгөн зардлыг тус тус бууруулж, түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн зардал, татварын байгууллагад төлсөн зардлыг тус тус нэмэгдүүлж залруулав.

Аудитаар 42.0 сая төгрөгийн зөрчил[2] илэрсэн тул албан шаардлага хүргүүлэв.

**3.1 Албан шаардлага**

Өнгөрсөн оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс тайлант хугацаанд сумын ИТХ-д суудалтай улс төрийн намуудад орон нутгийн төсвөөс 42.0 сая төгрөгийн дэмжлэг олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан нь Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д *“Нам дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно”*, 10.1.5-д *“энэ хуулийн 34.6-д заасан хориглосон этгээдээс хандив, тусламж, санхүүжилт шууд болон шууд бусаар авах”*, 34 дүгээр зүйлийн 34.6-д “*Нам дараах этгээдээс хандив авахыг хориглоно”,* 34.6.3-т “*төрийн байгууллага болон нутгийн өөрөө удирдах байгууллага*” гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй тул албан шаардлага хүргүүлэв.

---

[1] *Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,*

[2] *Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,*

Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5[3]-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ТЕЗ | 2 | 176.9 | 1 | 134.6 | 1 | 42.3 | 2 | 176.9 | | | | |
| ОНХС | 2 | 316.7 | 1 | 10.6 | 1 | 306.1 | 2 | 316.7 | | | | |
| “Орхон хот тохижилт” ОНӨӨААТҮГ | 5 | 46.6 | 4 | 13.7 | 1 | 32.9 | 5 | 46.6 | | | | |
| **Дүн** | **9** | **540.2** | **6** | **158.9** | **3** | **381.3** | **9** | **540.2** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ТЕЗ | 1 | 42.0 | | | 1 | 42.0 | | | | | | |
| ИТХ | 3 | 44.7 | | | 2 | 42.4 | 1 | 2.3 | | | | |
| ЗДТГ | 1 | 6.7 | | | | | 1 | 6.7 | | | | |
| ХХС | 2 | 66.3 | | | 2 | 66.3 | | | | | | |
| “Орхон хот тохижилт” ОНӨӨААТҮГ | 5 | 187.1 | 2 | 0.9 | 2 | 170.1 | 1 | 16.1 | | | | |
| **Дүн** | **12** | **346.8** | **2** | **0.9** | **7** | **320.8** | **3** | **25.1** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| ТЕЗ | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| ОНХСан | 1 | 95.9 | | | | | 1 | 95.9 |
| ЗДТГ | 1 | 23.1 | | | 1 | 23.1 | | |
| **Дүн** | **3** | **119.0** | | | **1** | **23.1** | **2** | **95.9** |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |

---

[3] *Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.*

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Дүн** | | | | | | | | |
| **Нийт дүн** | **3** | **119.0** | | | **1** | **23.1** | **2** | **95.9** |

## 5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 2 | 2 | | | 1 | 1 | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | |
| 3 | ОНТС | 2 | 1 | 1 | | | 1 | | |
| 4 | ОНӨҮГ | 1 | 1 | | | 1 | | | |
| 5 | ТЕЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| | **НИЙТ** | **6** | **5** | **1** | | **3** | **2** | | |